SARS-CoV-2 вирусийн эсрэг бүтээгдэж буй вакцинуудын ерөнхий тойм (Орчуулгын тойм өгүүлэл)

Yetian Dong[1,2], Tong Dai[3], Yujun Wei[4], Long Zhang[2], Min Zheng[1] and Fangfang Zhou[3]

[1]The State Key Laboratory for Diagnosis and Treatment of Infectious Diseases, National Clinical Research Center for Infectious diseases, Collaborative Innovation Center for Diagnosis and Treatment of Infectious Diseases, The First Affiliated Hospital, School of Medicine, Zhejiang University, Hangzhou 310058, China; [2]Life Sciences Institute and Innovation Center for Cell Signaling Network, Hangzhou 310058, China; [3]Institutes of Biology and Medical Science, Soochow University, Suzhou 215123, China and [4]Anhui Anlong Gene Technology Co., Ltd, Hefei 230041, China

Т.Хонгорзул, Ч.Гансүх, Б.Өлзийсайхан, Б.Энх-Амар, С.Цогтсайхан

АШУҮИС, БАС, Дархлаа судлалын тэнхим
khongorzul.t@mnums.edu.mn

Товч утга.

Амьсгалын цочмог халтай хамшинжийн коронавирус 2 (SARS-CoV-2) нь маш өндөр эмгэг төрүүлэх чанартай бөгөөд албан ёсоор коронавируст өвчин-19 (COVID-19) гэж нэрлээд байгаа дэлхий нийтийн цар тахлын үүсгэгч шинэ вирус юм. SARS-CoV-2-ийн эсрэг үр дүнтэй, аюулгүй эм, вакцин бүтээхээр ихээхэн чармайлт гарган ажиллаж байна. Идэвхигүйжүүлсэн вакцин, нуклейн хүчлийн вакцин, векторийн вакцин зэрэг вакцинуудын эмнэлзүйн судалгаа хэдийн эхэлчихээд байгаа юм. Энд бид SARS-CoV-2 вакцины туршилтын болон эмнэл зүйн судалгааны явцад гарган авсан үр дүнг тоймлон өгүүлсэн ба вакцин бүтээхэд анхаарах шаардлагатай аюулгүй байдлын зарим асуудлыг онцлон авч үзлээ. Бид мөн амьсгалын цочмог халтай хамшинжийн коронавирус (SARS-CoV) ба Дундад дорнодын амьсгалын хамшинжийн коронавирус (MERS-CoV) зэрэг бусад халдварт вирусийн эсрэг вакцин бүтээхэд ашигласан хэд хэдэн стратегийг нэгтгэн дүгнэв. Энэ нь SARS-CoV-2-ийн эсрэг эмчилгээний үр дүнтэй чиглэл боловсруулахад дэмтэй юм.


УДИРТГАЛ

Амьсгалын цочмог халтай хамшинжийн коронавирус 2 (SARS-CoV-2)-аар үүсгэгдсэн коронавируст өвчин (COVID-19) нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой асуудал болоод байна.[1–3] SARS-CoV-2 нь *Coronaviridae* бүлийн *Betacoronavirus*-ийн төрөлд харъяалагддаг, ихэвчлэн халуурах, хуурай ханиалгах, булчин сулрах, ядрах зэрэг амьсгалын замын шинж тэмдгээр илэрдэг.[4–6] Вирусийг илүү сайн ойлгохын тулд олон судалгаа хийж, COVID-19 цааш тархахаас сэргийлэх, үр дүнтэй, аюулгүй эм, вакцин бүтээх стратеги боловсруулаад байна.[7] Жишээлбэл, дэгээ уураг (S уураг), үндсэн протеаз (Mpro) ба РНХ-хамааралт РНХ полимераз (RdRp) зэрэг вирусийн уургийн бүтцийг тодорхойлж, SARS-CoV-2-ийн эсрэг эм гарган авах мэдээлэлтэй болсон.[8–10] Мөн SARS-CoV-2-аар өдөөгдсөн дархлааны урвалыг тодорхой болгосон нь эмчилгээний аргууд төгөлдөрших явцыг хурдасгаж байна. Гол нь COVID-19-ийг эмчлэх хоорондоо ялгаатай жижиг молекул бүхий эм, вакциныг бүтээгээд байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэдээлснээр 2020 оны 9 сарын 17-ны өдрийн байдлаар COVID-19-ийн 36 төрлийн вакцин эмнэлзүйн үнэлгээний шатанд, 146 төрлийн вакцин эмнэлзүйн үнэлгээний өмнөх шатанд байгаа аж. Вакциныг SARS-CoV-2 халдвараас сэргийлэх төдийгүй эмчлэхэд хэрэглэх боломжтой гэж үзээд бид SARS-CoV-2-ийн эмчилгээнд хэрэглэхээр бүтээж байгаа

вакцины сүүлийн үеийн дэвшлийн тухай ч тойм өгүүлэлдээ танилцуулж байна. Түүнчлэн, вакцин бүтээх явцад судлаачдад тулгарч болох аюулгүй байдлын асуудлыг нэгтгэн дүгнэв. Энэхүү тойм өгүүлэл нь COVID-19-ийг эмчлэх аргыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээн итгэж бид бусад эмгэгтөрөгчийн эсрэг вакцин бүтээхэд ашигласан, вакцины аюулгүй байдал ба үр нөлөөг сайжруулах зарим үр дүнтэй стратегийг ч бас тодорхойлж бичлээ.

SARS-CoV-2 вакцины бай антиген

SARS-CoV, MERS-CoV, SARS-Co-2 зэргийг оролцуулаад коронавирусууд нь эсийн цитоплазмд репликацид ордог, бүтцийн дөрвөн уурагтай (S уураг, бүрхүүлийн E уураг, мембраны M уураг, нуклеокапсидийн N уураг), эерэг утгат, дан утаслагт РНХ агуулсан вирус юм.[11] Ерөнхийдөө S уураг нь өвчний явцад дархлааны хариу урвалыг өрнөхөд шийдвэрлэх үүрэгтэй.[12] SARS-CoV-2 нь SARS-CoV-ийн адил S уургийнхаа тусламжтайгаар ангиотензин хувиргагч энзим 2 (ACE2) рецептороор нь дамжин эзэн биеийн эс рүү нэвтэрдэг.[13–15]



Зураг 1. SARS-CoV-2-оор өдөөгдсөн дархлааны хариу урвал

a. Төрөлхийн дархлааны хариу урвал. SARS-CoV-2 халдварын үед IFN-I ба IFN-III интерферoны түвшин буурч, үрэвслийн урьдал цитокины түвшин нэмэгддэг. SARS-CoV-2-ийн бүтцийн бус уураг 13 нь TBK1-тэй холбогдож, интерферoны нийлэгжилтийг саатуулна. ORF6 уураг нь мРНХ экспортын хүчин зүйл NUP98-Rae1-тэй харилцан үйлчилнэ. ORF9b нь Tom70-тай холбогдож MAVS-тай харилцан үйлчилдэг. **b**. Олдмол дархлааны хариу урвал. $CD4^+$ Т эсийн хариу урвал нь вирусийн S, M, N уургийн эсрэг голчлон, бүтцийн бус уураг 3, 4, ORF8 зэрэг уургийн эсрэг хэсэгчлэн өрнөнө. $CD8^+$ Т эс нь SARS-CoV-2-ийн M, N, S, бүтцийн бус уураг 6 болон ORF3a зэргийг танина. ORF8 нь олон төрлийн эсийн MHC-I молекулын илрэлийг бууруулна. SARS-CoV-2-ийн эсрэг голчлон S уураг өвөрмөц IgG, RBD өвөрмөц IgG үүсдэг ба харин IgM, IgA бага нийлэгждэг.

Тример бүтэцтэй S уураг нь S1 ба S2 гэсэн хоёр дэд нэгжтэй, тэдгээр нь рецептортой холбогдож, эсийн мембранд нэвтрэхийг нөхцөлдүүлдэг. S1 дэд нэгж нь рецептор холбогч домен (RBD) гэж нэрлэгддэг хэрчим агуулдаг ба тэр нь ACE2 рецептортой холбогдох чадвартай.[16,17] S уураг ACE2 рецептортой холбогдсоноор орон зайн бүрдмэл өөрчлөлтийг эхлүүлэх ба S уураг нэвтрэхийн өмнөх бүтцээс нэвтэрсний дараах бүтцэд шилжинэ. Нэвтэрсний дараах бүтцэд N-хэлхээт гликан нэмэгдэх ба энэ нь вирус эзний дархлааны хариу урвалаас зайлсхийх боломжийг үүсгэдэг гэж үзэж байна.[18] Өмнөх судалгааны дүн SARS-CoV-ийн S уургийн дарааллаар бүтээсэн вакцин нь туршилтын амьтанд болон эмнэлзүйн туршилтанд үр дүнтэй эсийн ба шингэний дархлааны урвалыг өдөөж байгааг харуулсан байдаг.[19–21] Үүнтэй төстөй байдлаар S генийг SARS-CoV-2 вакцины түлхүүр бай гэж үзэж байна.[22] Коронавирусийн S уураг, ялангуяа RBD нь саармагжуулагч эсрэгбие (NAbs) үүсгэх, Т эсийн дархлааны хариу урвалыг өдөөх чадвартай.[23–26] Амьтанд хийсэн судалгаа SARS-CoV-2-ийн RBD-д өвөрмөц IgG нь S уургаар өдөөгдсөн эсрэгбиеийн тэн хагас нь байгааг тогтоосон байна.[27] RBD-д өвөрмөц эсрэгбие ба Т эсийг SARS-CoV-2-ын халдвар аваад эдгэсэн хүмүүсийн ийлдэст илрүүлсэн байна.[28] Түүнчлэн, саармагжуулагч эсрэгбиеийн титр нь RBD-ийн эсрэг IgG-ийн түвшингээс үнэн магадтай хамаарч байсан дээрүндэслэн RBD-д өвөрмөц IgG нь SARS-CoV-2-ын халдварыг саармагжуулах чадварыг орлож чадна гэж үзсэн байна.[26,28] Цаашилбал, мэрэгчдийг RBD-оор дархлаажуулахад эхнээсээ эсрэгбие-хамааралт хүчжүүлэлтийн гаж урвал үүсгэлгүйгээр саармагжуулагч эсрэгбиеийг сайн үүсгэж байжээ.[29] Тиймээс RBD нь SARS-CoV-2-ийн вакцины хувьд найдлага төрүүлж байгаа бай хэсэг бөгөөд RBD-д суурилсан SARS-CoV ба MERS-CoV-ийн эсрэг вакцин хэрэглэх үед хуримтлуулсан мэдлэгийг SARS-CoV-2-ийн RBD-д суурилсан вакцин бүтээхэд ашиглах боломжтой юм. S уургаас гадна N уураг, M уураг, бүтцийн бус уургууд (nsp), дагалдах уургууд зэрэг бусад уураг нь антиген байж болно. Чухамдаа, вирусийн уураг, тэдний эзэн биеийн хүчин зүйлстэй харилцан үйлчлэл нь эзний дархлааны хариу урвал тэнцвэргүй байхтай,

тухайлбал I ба III хэвшинжийн интерферон (IFNI ба III) бага, үрэвслийн цитокин их байхтай холбоотой юм (Зураг 1а).[30,31] Сүүлийн үеийн судалгааны дүн SARS-CoV-2-ийн nsp13 нь TBK1-д үйлчлэх замаар, nsp15 нь RNF41-д үйлчлэх замаар интерфероны дохио дамжуулах замд нөлөөлдөг болохыг тогтоожээ. Нээлттэй унших хүрээ 6 (ORF6) гэж нэрлэх уураг нь мРНХ-ийн экспортын хүчин зүйл NUP98-Rae1-тэй харилцан үйлчилдэг. ORF9b нь митохондрийн вирусийн эсрэг дохио (MAVS)-ны уурагтай гадна мембраны транслоказ 70 (Tom70)-аар дамжуулан дам харилцан үйлчлэнэ.[32]

Мөн ORF8 нь эсийн лизосомд оруулж задлах замаар олон төрлийн эсийн гадаргуу дах эдийн тохирооны их бүрдлийн I анги (MHC-I)-ийн молекулын илрэлийг бууруулснаар антиген илчлэхийг саатуулан вирусаар халдварласан эсийг эс хордуулагч Т эс (CTL) устгах үйлийг бусниулдаг байна.[33] Коронавирусийн N уураг нь дархлааны өвөрмөц CTL эсүүдийг идэвхижүүлдэг болохыг өмнөх судалгаа харуулсан.[34–37] Үүнээс гадна саармагжуулагч эсрэгбиеийн титр нь N уурагт өвөрмөц Т эсийн тоотой шууд хамааралтай байгаагаас үүдэн саармагжуулагч эрэгбиеийн ялгарал нь вирусийн эсрэг Т эсийн идэвхижилтэй холбоотой гэж үзэж байна.[28,38] Өөр нэг судалгааны дүн М уургийн эсрэг ийлдэс нь SARS-CoV-ийн халдварыг саармагжуулах өндөр идэвхитэй байсан, иймээс М уураг нь уурагт суурилсан үр дүнтэй вакцин гарган авахад чухал хэмээн мэдээлсэн байна.[39] Саяхан Грифони нар $CD4^+$Т эсийн хариу урвал нь анхнаасаа вирусийн S, M, N уургийн эсрэг чиглэсэн байдаг ч nsp3, nsp4 ба ORF8-ын эсрэг хэсэгчлэн өрнөж байгааг тэмдэглэсэн байна (Зураг 1b).[40] $CD8^+$Т эсийн хариу урвалын хувьд SARS-CoV-2-ийн М ба S уургууд маш сайн танигддаг ба nsp6, ORF3a, N уургийн эсрэг мэдэгдэхүйц урвалж байдал ажиглагдаж байжээ (Зураг 1b).[40] Дээрхи үр дүн нь S уургаас гадна SARS-CoV-2-ийн эсрэг $CD8^+$Т эсийн хариу урвалыг өдөөж чадах хамгийн тохиромжтой вакцин бүтээхэд М уураг, nsp6, ORF3a ба/эсвэл N уураг зэргээс гаралтай I ангийн нэмэлт эпитопууд тустай байхаар байна. Гэвч тэднийг бай антиген болгон ашиглах боломжийг цаашид судлах шаардлагатай байгаа юм.

Уг өгүүлэл нь 2020 оны 10 сарын 13-ны өдөр Nature сэтгүүлийн бүрдэл сэтгүүл болох Signal Transduction and Targeted Therapy сэтгүүлд нийтлэгдсэн. Үүнээс хойш гарсан мэдээ мэдээллийг орчуулагчид өгүүлэлд нэмж оруулсан нь орчуулагчийн шигтгээ хэсгээр бичигдсэн. Хэвлэлийн тоймд иш татсан мэдээллийн эх сурвалжийг нэмж оруулаа.

Бүтээж буй SARS-CoV-2-ийн вакцин

Идэвхигүйжүүлсэн вакцин ба амьд сулруулсан вакцин


Цар тахлын үед COVID-19-ийн эсрэг вакциныг яаралтай бүтээх шаардлагатай уялдан идэвхгүйжүүлсэн вакцин, нуклейн хүчлийн вакцин, аденовируст суурилсан вакцин, рекомбинант дэд нэгжийн вакцин зэргийг оролцуулаад олон төрлийн вакциныг бүтээхээр ажиллаж байна (Зураг 2). Физик эсвэл химийн аргаар идэвхгүйжүүлсэн вирус нь халдвар үүсгэдэггүй бөгөөд дархлаа тогтолцоогоор танигддаг вирусийн олон төрлийн уурагтай, орон зайн хамааралт антигений эпитопуудыг тогтвортой илрүүлдэг, мөн их хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой зэргээрээ сонирхол татдаг.[41] Цэвэршүүлж идэвхигүйжүүлсэн вирусийг вакцин бүтээхэд ашигладаг уламжлалтай ба томуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэхэд үр дүнтэй нь тогтоогдсон. SARS-CoV-2 эсрэг бүтээж буй идэвхгүйжүүлсэн вакцин болох BBIBP-CorV нь туршилтын амьтанд чадамжтай, аюулгүй болох нь тогтоогдсон учир цаашид эмнэлзүйн туршилтанд хамрагдахаар болсон.[42] Цэвэршүүлж, идэвхгүйжүүлэн бүтээж буй вакцин болох PiCoVacc-ийг үнэлсэн өөр нэг судалгааны дүн энэ вакцин хулгана, харх, макака бичинд цитокины мэдэгдэхүйц өөрчлөлт үүсгэлгүй, мөн макака бичинд эмгэг шинж илрүүлэлгүйгээр саармагжуулагч эсрэгбие үүсгэж байгааг харуулсан байна.[27] Синовакийн бүтээж байгаа хөнгөн цагааны гидроксид агуулсан идэвхгүйжүүлсэн SARS-CoV-2 вакцин эмнэлзүйн туршилтын 2 дугаар шатанд 6 мкг/0.5 мл эсвэл 3 мкг/0.5 мл тунгаар 2 удаа хэрэглэхэд эрүүл насанд хүрэгчдэд гаж нөлөөгүй, дархлаа тогтоосон дүн үзүүлээд эмнэлзүйн 3 дугаар шатанд шилжээд байна (Хүснэгт 1).[43]

Орчуулагчийн шигтгээ

> Сүүлийн үеийн мэдээгээр уг компаний Бразил улсад зохион байгуулж буй эмнэлзүйн туршилт нь хэд хэдэн судалгаанд оролцогчдод гаж нөлөө үзүүлсэн шалтгаанаар үргэлжлэхээ больжээ.

Ухан хотын Биологийн бүтээгдэхүүний хүрээлэн ба Синофармын хамтран бүтээж буй идэвхгүйжүүлсэн SARS-CoV-2 вакцины эмнэлзүйн 2 дугаар шатны туршилтын үр

дүнгээс харахад 0, 14 болон 0, 21 дэх хоногт тарьсан 2 удаагийн тун хэрэглэсэн оролцогчдод саармагжуулагч эсрэгбиеийн геометрийн дундаж титр нь 121 ба 247 байсан ба зөвхөн шилжмэл, зөнгөөрөө арилдаг гаж урвал ажиглагдаж байсан байна.[44]



Зураг 2. Олон төрлийн вакцины тойм, тэдгээрийн давуу болон сул тал

Орчуулагчийн шигтгээ

Уг вакцины эмнэлзүйн 3 дугаар шатны туршилт дуусах дөхөж байгаа бөгөөд сүүлийн шалгалтыг хийж байна.

Амьд сулруулсан вакциныг нь цэцэг болон халдварт саа өвчинтэй тэмцэхэд амжилттай хэрэглэсэн юм.[45] Антиген болгож сулруулсан вирус ашигласан SARS-CoV-2-ийн амьд сулруулсан 3 вакцин эмнэлзүйн өмнөх туршилтын үе шатанд туршигдаж байна. Гэхдээ ийм вакцины омгууд зарим тохиолдолд хоруу чанартай болж болох юм. Вирусийг вакцин бүтээхэд ашиглаж болох ч саармагжуулагч эсрэгбие үүсгэдэггүй вирусийн эпитоп бүтцэд нь ордог буюу энэ нь солбилцсон хамгаалалт үүсгэж дархлааны хамгаалах урвалыг гажуудуулах боломжтой зэрэг нь анхаарал татаж байгаа учир цаашдын нарийн судалгаа шаардлагатай юм.

Нуклейн хүчлийн вакцин

Үүнд мРНХ-ийн вакцин болон ДНХ-ийн вакцин зэрэг нуклейн хүчилд суурилсан вакцин нь өргөн хэрэглэдэг вакцины төрөл юм. Эдгээр вакциныг хүний эс рүү оруулахад эсэд вирусийн уураг хуулагдан нийлэгждэг. Коронавирусийн уургуудаас S уургийг вакцин бүтээхэд түгээмэл хэрэглэж байна. мРНХ-ийн вакцин нь өндөр үр дүнтэй, хурдан бүтээж эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэх боломжтой зэргээрээ уламжлалт вакцинаас илүүтэй найдлага төрүүлэхээр сонголт болоод байна.[46,47] Гэсэн хэдий ч мРНХ-ийн өөрийн физик химийн шинж чанар нь вакциныг эсэд нэвтрэн орох ба эрхтэнд тархахад нөлөөлөх боломжтой бөгөөд мРНХ-ийн вакциныг хүнд хэрэглэхэд аюулгүй, үр дүнтэй байх нь тодорхойгүй хэвээр байна. Pfizer ба BioNTech-ийн бүтээж буй S уургийн RBD-ийг онилсон РНХ-ийн вакцины (BNT162b1) 1 ба 2 дугаар үе шатны судалгаа вакцин хийсэн ихэнх хүнд хөнгөнөөс дунд зэргийн хэсгийн ба ерөнхий шинж тэмдэг илэрснийг, вакцинжуулалтын хоёр дахь тунгийн дараа COVID-19-өөр өвчилж эдгэрсэн хүмүүсийн ийлдэст байгаагаас өндөр агууламжтай эсрэгбие үүсгэж байгааг мэдээлжээ (Хүснэгт 1).[48]

Орчуулагчийн шигтгээ

2020 оны 12 сарын 2-ны байдлаар Pfizer ба BioNTech-ийн мРНХ вакцин эмнэлзүйн 3 дугаар шатны туршилтыг дуусгасан бөгөөд анх Их Британид албан ёсоор хэрэглэхийг зөвшөөрчээ. Эмнэлзүйн 3 дугаар шатны туршилтын тайлангаас харахад уг вакцин нь 95%-ийн хамгаалах чадвартай. Дархлаа тогтоход вакцины 2 удаагийн тун хийх шаардлагатай бөгөөд эхний тунг тариулсанаас хойш 12 дахь хоногт саармагжуулагч эсрэгбие үүсч эхлэнэ. Хоёр дахь тунг 21 дэх хоногт хийх бөгөөд 28 дахь хоногт дархлаа тогтсонд тооцно. Pfizer-ийн вакцины удаан хугацаанд
- 70°C-д, 5 хоног хүртэлх хугацаанд 2-8°C-д хадгалахад тогтвортой[49].

SARS-CoV-2-ийн S уургийн тогтворжуулсан, эрэмблэгдээгүй (prefusion буюу эсийн мембрантай холбогдож нэвтрэхийн өмнөх төлөвт байгаа) S уургийг кодлосон мРНХ-1273-ийг үнэлсэн эмнэлзүйн 1 дүгээр шатны туршилтын дүн, вакцины дараалсан 2 тун нь хүнд хэлбэрийн гаж нөлөө үзүүлээгүй, мөн саармагжуулагч эсрэгбиеийн ба $CD4^+$ Th1 эсийг хамарсан урвалыг өдөөж байгаа тухай мэдээлжээ (Хүснэгт 1).[50]

Орчуулагчийн шигтгээ

Moderna компанийн бүтээж байгаа энэ вакцины эмнэлзүйн 3 дугаар шатны туршилтанд 30,000 оролцогчийг хамруулсан бөгөөд 94,5%-ийн хамгаалах чадвартай байна. Хоорондоо 4 долоо хоногийн зайтай 2 удаагийн тун тариулна. Pfizer-ийн вакцинтай харьцуулахад хадгалах нөхцөл нь энгийн өөрөөр хэлбэл -20°C-д 6 сар тогтвортой байна[51].

Хятадын цэргийн судалгааны төвийн хөгжүүлж буй ARCoVмРНХ вакцин нь амьтны туршилтын шатыг амжилттай дуусгасан байна.

SARS-CoV-2-ийн S уургийн RBD-ийг кодлосон липидийн нано хэсгээр бүрэгдсэн мРНХ-ийн ARCoV хэмээх вакцин хоёр удаагийн тунгийн дараа хулгана болон сармагчин дээр SARS-CoV-2-ийн эсрэг хамгаалалтыг үүсгэж чадаж байсан. Үүнээс гадна, энэ вакциныг тасалгааны хэмд хадгалж болохоор байгаа нь тээвэрлэлт хийхэд илүү тохиромжтой нөхцөл юм. [52] ДНХ-ийн вакцин нь Т эсийн идэвхжлийг эрчимжүүлж, эсрэгбие үүсгэдэг, плазмидын ДНХ нь өндөр био нийцэлтэй, үйлдвэрлэлийн өртөг бага, хадгалах хугацаа удаан зэргээрээ эмчилгээний нэн өндөр нөөцтөй юм.[53] Гэхдээ ДНХ-ийн молекул нь хуулбарлагдахын тулд бөөмийн мембраныг нэвтрэх шаардлагатай байдаг, ерөнхийдөө дархан төрүүлэх чанар багатай зэрэг сул талтай. SARS-CoV-2-ийн S уургийн өөр өөр хэлбэрийг кодлосон ДНХ-ийн вакцинуудаар дархлаажуулсан резус макака бичинд эсийн ба шингэний дархлааны урвал өдөөгдөж, вакцинаар үүсгэгдсэн саармагжуулах эсрэгбиеийн титр нь хамгаалах чадвартай байсныг илрүүлжээ.[54] ДНХ-ийн вакцинаар II хэвшинжийн Т туслагч эс (Th2) бус I хэвшинжийн Т туслагч эс (Th1) өдөөгддөг ба резус макака бичинд эмнэлзүйн өвчин даамжрах шинж илрэхгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч MERS-CoV–ийн ДНХ-ийн вакцин нийт судалгаанд оролцогчдын тал хувьд нь л саармагжуулагч эсрэгбие үүсгэсэн, үүссэн эсрэгбиеийн хэмжээ даган ажиглах үед мэдэгдэхүйц буурсан байгааг анхааруулсан судалгаа байна.[55] Иймд дараа дараагийн судалгаанд ДНХ-ийн вакцин нь урт хугацааны саармагжуулагч эсрэгбие үүсгэх идэвхитэй эсэх, саармагжуулдаггүй эсрэгбие үүсч хамгаалалтыг сулруулдаг, эсвэл хүнд хэлбэрийн өвчин үүсгэдэг эсэхэд анхаарвал зохино.

Векторийн вакцин

Векторийн вакциныг ерөнхийдөө адено эсвэл покс (рох) вирус зэрэг тээгч вирусд өөр вирусийн тохиромжтой генийг, голчлон коронавирусийн S генийг суулган инженерчлэх аргаар бүтээдэг. Векторийн вакцины үндсэн давуу тал нь иммуноген нь өвөрмөц дархлаа өрнөхөд зайлшгүй шаардагддаг төрөлхийн дархлааг өдөөдөг өөр вирусийн халдвартай хамт экспресслэгддэгт оршдог.[56] Гэсэн хэдий ч энэ стратегийн үед тээгч вирусийн эсрэг дархлааны хариу урвал давамгай өрнөж цөөн тооны коронавирусийн антиген эзний дархлаа тогтолцоонд илчлэгдсэнээс түүний эсрэг урвал хязгаарлагдсан байж бол ох юм. CanSino Biological Inc ба Бээжингийн Биотехнологийн Хүрээлэнгийн хамтран бүтээсэн SARS-CoV-2-той рекомбинант аденовирус 5 (Ad5) векторийн вакцины эмнэлзүйн туршилтын үр дүн 1 мл-д 5×10^{10} вирусийн биенцэртэй тун нь 1×10^{11} тунгаас илүү аюулгүй, түүнтэй харьцуулахуйц дархлааны урвал өдөөж байсан байна (Хүснэгт 1).[57] Гэсэн хэдий ч өмнө нь үүссэн Ad5-ын эсрэг дархлаа ба нас ахимаг байх нь саармагжуулагч эсрэгбиеийн урвалыг сулруулдаг, мөн өмнө халдвар авч байсан нь Т эсийн дархлаажуулалтын дараах урвалд нөлөөлдөг байж болох юм.[58] Тиймээс вакцины үр дүнтэй байдалд нөлөөлөх эдгээр асуудалд цаашдын судлалгааг чиглүүлэх шаардлагатай. Оросын холбооны улсын Н.Ф.Гамелейн нэрэмжит тархвар судлал, бичил амь судлалын эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтээсэн SARS-CoV-2-ийн S генийг суулгасан 2 төрлийн рекомбинант аденовирусийн (rAd26+ rAd5) векторийн вакцины (Спутник 5) эмнэлзүйн 1 ба 2 дугаар шатны судалгааны дүнгээр rAd26 эсвэл rAd5 векторт өмнө нь үүсгэсэн байсан дархлааны урвал нь РХД-д өвөрмөц эсрэгбиеийн агууламжид нөлөөлөхгүй байгааг харуулсан байна (Хүснэгт 1). Тиймээс хам вакцинжуулалт нь вакцины векторын эсрэг үүссэн дархлааны урвалын сөрөг нөлөөг бууруулах сайн сонголт байж болох юм.[59]

Орчуулагчийн шигтгээ

> Вакцин бүтээгчдийн мэдээлсэнээр эмнэлзүйн 3 дугаар шатны туршилтын дүнгээр уг вакцин нь 92%-ийн хамгаалах чадвартай болохыг гаргажээ.

Оксфордын их сургууль болон Астра Зенека компанийн хамтран бүтээж буй шимпанзе бичний адено вектор (ChAd) SARS-CoV-2-ийн кодонд оновчтой болгосон бүтэн урттай S уургийг кодлосон вакцины (ChAdOx1 nCoV-19) үр дүн, аюулгүй байдал ба дархан төрүүлэх чадварыг тодорхойлсон эмнэлзүйн 3 дугаар шатны судалгааг хийжээ. Эмнэлзүйн өмнөх шатны туршилтаар SARS-CoV-2 –ийн геномын РНХ судалгаанд хамрагдсан бүх бичний хамрын арчдаст илэрсэн ба вирусийн ачаалал ChAdOx1 nCoV-19-ээр дархлаажуулсан ба хяналтын амьтадад халдааснаас хойшхи бүх өдрүүдэд ялгаагүй боловч дархлаажуулсан амьтад уушгины үрэвсэл ба дархлаа-хүчжүүлэлтийн өвчин үүсэхгүй байгааг тогтоожээ.[60] Харин эмнэлзүйн 1 ба 2 дугаар шатны туршилтын явцад ChAdOx1 nCoV-19 нь аюулгүй, гаж нөлөөгүй, дархан төрүүлдэг болохыг тогтоосон байна. Түүгээр ч зогсохгүй өвдөх, халуурах, булчингаар янгинах зэрэг хэсгийн ба түгээмэл урвалууд парацетамол хэрэглэхэд намжиж байв (Хүснэгт 1).[61] Аюулгүй байдал нь вакцин бүтээхэд хамгийн их анхаарах асуудал учраас SARS-CoV-2 вакциныг туршихдаа аюулгүй байдлыг сайжруулахад илүү анхаарал хандуулах шаардлагатайг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 1. Эмнэлзүйн 3 дугаар шатны вакцин хөгжүүлэлтийн байдал

Вакцины төрөл	Вакцин	Хөгжүүлэгч	Эмнэлзүйн шат	Тунгийн тоо	Тунгийн давтамж	Эмнэлзүйн туршилтын үр дүн	Эх сурвалж
Идэвхгүйжүүлсэн вакцин	Хөнгөн цагааны гидроксидтой SARS-CoV-2-ийн идэвхгүйжүүлсэн вакцин	Синовак	3 шат	2	0, 14 дэх өдөр	2 шатанд вакцины 6μг/0.5мл эсвэл 3μг/0.5мл хоёр тун нь эрүүл насанд гаж нөлөөгүй, дархлаа тогтоосон. 3 μг тун нь 0, 14 хоногт 92.4%, 0, 28 хоногт 97.4% өвөрмөц эсрэгбие үүсгэж байсан.	43
	Идэвхгүйжүүлсэн	Уханий биологийн бүтээгдэхүүний хүрээлэн/Синофарм	3 шат	2	0, 14 эсвэл 0, 21 дэх өдөр	2-р шатны туршилтаар NAbs-ийн GMT-ууд 0, 14 болон 0, 21 өдрүүдэд тус тус 2 удаа вакцин хийлгэсэн оролцогчдод 14 хоногийн дараа 121 ба 247 саармагжуулагч эсрэгбие үүсч байсан. 0, 14 дэх өдөр вакцин тариулсан хүмүүсийн 6%-д, 0, 21 дэх өдөр вакцин тариулсан хүмүүсийн 19.0% -д 7 хоног гаж нөлөө илэрсэн.	44
	Идэвхгүйжүүлсэн	Бээжингийн биологийн бүтээгдэхүүний хүрээлэн/Синофарм	3 шат	2	0, 14 эсвэл 0, 21 дэх өдөр	Тодорхойгүй	тодорхой биш
РНХ вакцин	BNT162b1	Pfizer/Fosun Pharma/BioNTech	3 шат	2	0, 28 дэх өдөр	1/2 шатны судалгаагаар ихэнх оролцогчдод вакцины нөлөөгөөр хөнгөн, дунд зэргийн, хэсгийн болон ерөнхий шинж тэмдэг илэрч байсан, 10 ба 30 μг хоёр дох тунгийн дараа саармагжуулагч эсрэгбиеийн титр 1.8-2.8 дахин нэмэгдсэн.	48
	мРНХ-1273	Moderna/NIAID	3 шат	2	0, 28 дэх өдөр	1-р шатны судалгаагаар вакцины 2 тун нь ноцтой гаж нөлөөгүй байсан бөгөөд вакцин нь саармагжуулагч эсрэгбие ба Th1-өөрчлөлттэй $CD4^+$ Т-эсийн хариу урвалыг үүсгэдэг гэж мэдээлсэн.	49
Репликацийн бус вектор вакцин	Аденовирус 5 төрлийн вектор	Бээжингийн биотехнологийн хүрээлэн/CanSino Biological Inc	3 шат	1	тодорхой биш	2-р шатны туршилтаас харахад 1 мл тутамд 5×10^{10} вирусийн хэсгийг агуулсан вакцин нь 1×10^{11} вирусийн хэсгийг агуулсан вакцинаас гаж нөлөө багатай байсан бөгөөд адил түвшинд дархлааны хариу урвалыг өдөөж байсан. Гэвч өмнө нь байсан Ad5-ийн дархлаа саармагжуулагч эсрэгбиеийн урвалыг бууруулж, Т эсийн дархлааны хариу урвалд нөлөөлж байсан.	55
	ChAdOx1 nCoV-19	Оксфордын их сургууль/AstraZeneca	3 шат	1	тодорхой биш	1/2 шатны туршилтаар нэг тунгийн дараа оролцогчдын 91%-д MNA80 саармагжуулагч эсрэгбие, оролцогчдын 100%-д PRNT50 саармагжуулагч эсрэгбие тодорхойлогдож байжээ. Өдөөх тунгийн дараа бүх оролцогчдод саармагжуулах үйл ажиллагаа явагдаж байсан. Өвдөлт, халуурал, булчин өвдөх зэрэг хэсгийн болон ерөнхий урвалыг парацетамолоор багасгах боломжтой.	59
	Аденод сууриласан (rAd26-S + rAd5-S)	Гамалегийн судалгааны хүрээлэн	3 шат	2	0, 21 дэх өдөр	1/2 шатны туршилтаас харахад rAd26-S ба rAd5-S вакциныг хуурайшуулсан болон хөлдөөсөн байдлаар зэрэг хэрэглэхэд 42 дах өдөр оролцогчдод 100% саармагжуулагч эсрэгбиеийг үүсгэж байсан. rAd26 ба rAd5 векторуудын эсрэг үүссэн байсан дархлааны хариу урвал нь РХД өвөрмөц эсрэгбиеийн титрт нөлөөлөхгүй байсан.	57
	Ad26COVS1	Жанссен эмийн компани	3 шат	2	0, 56 дах өдөр	Туршилтын амьтанд хийсэн туршилтаас харахад S антигенийг кодлосон Ad26 вектор агуулсан вакцины нэг удаагийн тун нь саармагжуулагч эсрэгбиеийн хариу урвалыг өдөөж бүрэн хамгаалж байсан. Иммуноген нь бүрэн урттай мембран холбоот S уураг, фурины задралын хэсгийн мутаци, пролиныг тогтворжулдаг хоёр мутаци зэрэг байгалийн үндсэн дараалыг агуулдаг.	60

Орчуулагчийн шигтгээ

Эмнэлзүйн 3 дугаар шатны туршилтын урьдчилсан дүнгээс харвал уг вакцин нь 70-90% хамгаалах чадвартай. Вакцинжуулалт нь 1 сарын зайтай хоёр тун тарилгаас бүрдэнэ. Хэрвээ эхний тунг хагас хэмжээгээр удаах тунг бүтэн хэмжээгээр хийвэл 90% хамгаалах чадвартай, хоёр тунг хоёуланг нь бүтэн хэмжээгээр хийвэл 70% хамгаалах чадвартай гэж 3 дугаар шатны туршилтын мэдээнээс дүгнэж болохоор байна.

Janssen Pharmaceutical компанийн бүтээсэн AD26COVS1 вакцины эмнэлзүйн 3 дугаар шатны туршилт эхэлсэн бөгөөд түүний эмнэлзүйн өмнөх судалгаа эрэмблэгдээгүй, тогтворжуулсан S уургийг кодлосон Ad26 вектороор нэг удаа дархлаажуулахад саармагжуулагч эсрэгбиеийн чадамжтай урвал үүсч, дархлаажуулсан макака бичнүүдийг сайн хамгаалж байгааг харуулсан байна (Хүснэгт 1).[62]


Дэд нэгжийн вакцин ба вирус төст биенцэрийн вакцин

Дэд нэгжийн вакцин нь түүнд байх вирусийн дан уургийг биед нь тарьснаар амьтан ба хүнийг вирусийн халдвараас хамгаалах үр дүнтэй. Гэхдээ вирусийн антигенийг иж бүрнээр төлөөлөх боломжгүй цөөхөн бүрдэл хэсгийг агуулдгаас түүний хамгаалах үр дүн хязгаарлагдмал байх, мөн зарим тохиолдолд тэнцвэргүй дархлааны урвал өдөөх боломжтой.[63] Yang нар SARS-CoV-2–ийн RBD-ийн 319-545 дахь үлдэгдлээс тогтсон бөгөөд бакуловирусийн экспрессийн системээр дамжуулан гарган авсан дэд нэгжийн вакциныг бүтээжээ. Вакцины эмнэлзүйн өмнөх туршилт бичийг SARS-CoV-2 халдвараас бага хоруу чанартай хамгаалж чадаж байгааг мэдээлсэн байна (Хүснэгт 2).[64] Вирус төст биенцэр (VLPs) нь вирусийн капсидын уургуудаас бүрдэх уурагт суурилсан вакцины нэг төрөл юм.[65] Вирус төст биенцэр нь давтагдсан бүтэцтэй тул дархлааны эрчимтэй урвалыг өдөөдөг ба удмын материалгүй тул бусад төрлийн вакцинаас илүү аюулгүй байдаг. Жинхэнэ вирустай төстэй вирус төст биенцэрийг бүтээх нь халдварын эсрэг үр дүнтэй вакцин боловсруулахад чухал алхам болно. Одоогийн байдлаар хэд хэдэн баг рекомбинант уурагт суурилсан вакцины инженерчлэл дээр ажиллаж байгаа ч эмнэлзүйн туршилтын үр дүн нь өнөөдрийг хүртэл нийтлэгдээгүй байна. Вакцин бүтээх нь олон өөр туршилтын загварыг хамарсан, итгэмжилсэн вакцин бүтээхэд их хугацаа зарцуулдаг, сунжирсан, өртөг өндөртэй үйл явц байдгийг үл харгалзан COVID-19 өвчнөөс сэргийлэх, эмчлэх вакциныг үргэлжлүүлэн бүтээх амин чухал шаардлага тавигдсаар байна.

SARS-COV-2-ийн эсрэг саармагжуулагч эсрэгбие

Саармагжуулагч эсрэгбие нь вирустхалдварыг хянахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.[66] Хамгийн түгээмэл хэрэглэдэг эсрэгбиеийн тухай ойлголтод моноклон эсрэгбие (mAbs), нэг доментэй эсрэгбие, нэг гинжит хувьсамхай хэрчим (scFvs), үйл ажиллагааны антиген холбогч хэрчим (Fabs) зэрэг хамаарна (Зураг 3а). Вирусийн халдвар аваад эдгэрсэн хүмүүсээс (Зураг 4а) эсвэл дархлаажуулсан трансген туршилтын амьтнаас моноклон саармагжуулагч эсрэгбиеийг ялган авч болно (Зураг 4b). Саармагжуулагч эсрэгбие нь, ялангуяа SARS-CoV-2-ийн рецептор холбогч домен (RBD)-ийг онилсон эсрэгбие нь вирусийн халдварын эмчилгээний найдлага төрүүлсэн арга байж болох юм (Хүснэгт 3).[67,68] RBD-ийн хоорондоо өрсөлддөггүй гурван эпитопийг (тухайлан нэрлэвэл, RBD-A, RBD-B ба RBD-C) саяхнаас ялган тодорхойлсноос RBD-A-г хамгийн тохиромжтой бай гэж үзэж байна. RBD-A-г чиглэсэн саармагжуулагч эсрэгбие болох CC12.1 нь псевдовирусийг саармагжуулах чадвартайгаа харуулсан.[69] BD-368–2, B38, H4, B5, CB6, CV30 зэрэг саармагжуулагч эсрэгбие нь RBD-ийг холбож, RBD-ACE2-ын харилцан үйлчлэлийг саатуулж байсан.[70–76] 47D11 ба H2 саармагжуулагч эсрэгбие нь S уураг-рецепторын харилцан үйлчлэлийг саатуулахгүй байсан боловч SARS-CoV-2-ийн RBD эпитоптой холбогдох чадвартай байв.[71,77] Нэг судалгааны үр дүн ACE2-той өрсөлдөгч эсрэгбиеүүд нь ACE2-ын холбогдохыг хориглож, S1-ийн задралыг өдөөснөөр вирусийн халдварыг саатуулж байгааг, үүгээрээ эсрэгбиеийн авцаал чанар ба эсрэгбиеийн чадавхийн хооронд сул хамааралтай байгааг харуулсан байна.[68] Өөр нэгэн судалгааны үр дүн ийлдсийн RBD холбох чадвар ба вирус саармагжих нь хоорондоо хамааралтай байгааг мэдээлжээ.[69] Саармагжуулагч эсрэгбиеийн саармагжуулах идэвхид нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлохын тулд нэмэлт судалгаа, шинжилгээ шаардлагатай байна. SARS-CoV ба SARS-CoV-2-ийн төстэй шинж чанарт үндэслэж SARS-CoV-2-той солбилцон үйлчилдэг SARS-CoV-ийн саармагжуулагч эсрэгбиеийг тодорхойлохоор судлаачид ажиллаж байна. SARS-CoV-ийн халдвар авч байсан хүнээс

ялгаж авсан S309, ADI-55689, ADI-56046 зэрэг эсрэгбиеүүд нь SARS-CoV-2-ийг солбилцон саармагжуулж байсан байна.[68,78] S уургийн доторх гликан агуулсан тогтмол эпитопийг онилсон S309 эсрэгбие нь эсрэгбие хамааралт эсийн эс хордуулалт (ADCC) ба эсрэгбие хамааралт эсийн залгилт (ADCP) зэрэг талсжсан хэрчим (Fc)-хамааралт эффектор механизмийн идэвхитэй болохоо харуулсан байна.[78] Түүнээс гадна цөөвтөр тооны саармагжуулагч эсрэгбие RBD-ний бус хэсгийг онилдог байна (хүснэгт 3). Жишээ нь CV1 болон түүний клоны хувилбар CV35 нь RBD-оос өөр эпитоптой холбогддог ба хоёулаа RBD-ний бүсэд чиглэсэн CV30-аас сул чадавхтай байжээ.[76] Цаашид хийх судалгаа нь эдгэрсэн хүмүүсээс ялгаж авсан чадавхтай саармагжуулагч эсрэгбиеийг тодорхойлоход төвлөрвөл зохино. Түүнчлэн, Хөрвүүлсэн вакцин судлалын 2.0 аргачлалыг (бичил биетний геномын мэдээлэлд суурилсан вакцин бүтээх аргачлал) ашиглан хийсэн бүтцийн шинжилгээний дүн дархан төрүүлэх хэрчмийн загвар ба вакцины стратегийн чиглэлд дэвшил гаргахуйц саармагжуулагч эсрэгбиеийн оновчтой эпитопийг нээн илрүүлж болохоор байгааг харуулсан (Зураг 3b).[79] Бөхтний (тэмээний) овгийн амьтад ердийн эсрэгбиеэс гадна нэг ерөнхий хувьсамхай доментой (нано биенцэр), гинж тус бүр нь хос тогтмол хэрчимтэй хоёр хүнд гинжээс тогтох хүнд гинжит эсрэгбие (HCAbs) ялгаруулдаг. Нано биенцэрийг вирусийн уургаар дархлаажуулсан тэмээнд, эсвэл хүнд тодорхойлсон дараалыг ашиглан бүтээж болохоор байгаа юм (Зураг 4c). Уламжлалт эсрэгбиетэй харьцуулахад нано биенцэр нь жижиг хэмжээтэй, илүү олон эпитоптой холбогдох чадвартай, үйлдвэрлэлийн зардал бага, прокариотын ялгаруулах тогтолцоо ашиглан их хэмжээгээр нийлэгжүүлэх боломжтой зэрэг хэд хэдэн хосгүй онцлог шинжтэй.[80] Мөн нано биенцэрийг ингаляцийн аргаар халдварын голомтод шууд хүргэж болох учир тухайлбал, амьсгалын замын өвчнийг ашиглахад үр дүнтэй байхаар байна.[81] Нано биенцэрийг тэмээнээс ялган авдаг нь хүнд дархан төрүүлж болох, Fc-хамааралт эффектор үйл байдаггүй зэрэг нь эмчилгээнд ашиглахад сул тал болж болох юм. Гэхдээ нано биенцэрийг хүнийжүүлэх, эсвэл бүхэлдээ хүний эсрэгбие бүтээх замаар төгөлдөржүүлэх боломжтой юм.[82] SARS-CoV-ийн RBD-ийг онилсон нэг доментэй эсрэгбие болох VHH-72 нь SARS-CoV-2-ийн RBD-тэй солбицон үйлчилж үүгээрээ RBD-рецептор холболтыг саатуулж байсан байна. Түүнчлэн хоёр валенттай VHH-72-Fc бүтэц нь SARS-CoV-2 S псевдовирусийг саармагжуулах идэвхитэй болохыг харуулсан байна.[83] SARS-CoV-2-ийн S1-ийг хөтөч антиген болгон ашиглаж эсрэгбиеийн сангаас тодорхойлсон бүрэн хүний шинжтэй нэг доментэй эсрэгбиеийн дүн шинжилгээгээр n3088 ба n3130 эсрэгбие нь тример дэгээ уургийн нүүрэн хэсэгт байрлах далд эпитопыг бай болгосноор SARS-CoV-2-ийг саармагжуулж байсныг тогтоосон ч тэдгээр нь SARS-CoV-2-ийн RBD-той холбогддог ACE2 рецептортой өрсөлдөхөөргүй байв.[84] Эдгээр хоёр төрлийн эсрэгбие нь хүний дараалаас хуулбарласан учир тэмээн төрөлтнөөс ялгасан, эсвэл хүнийжүүлсэн нано биенцэрээс сул дархан төрүүлэх шинжтэй байхаар найдлага төрүүлсэн сонголт болж болох юм.



Зураг 3. Коронавирусийн эсрэг саармагжуулагч эсрэгбие ба хөрвүүлсэн вакцин судлал 2.0-ийн схем.


a. Моноклон эсрэгбие (mAbs), нэг доментэй эсрэгбие, scFvs, Fabs зэрэг саармагжуулагч эсрэгбие нь RBD бүхий вирусийн уургатай холбогддог. Саармагжуулагч эсрэгбие нь ихэвчлэн S1 болон S2 дэд нэгжийг бай болгон вирусийг рецептортой холбогдож, эсийн мембранаар нэвтрэхийг хориглодог. **b**. Хөрвүүлсэн вакцин судлал 2.0-ийн схем. Эдгэрч буй өвчтнөөс эсрэгбиеийг ялган авч in vitro болон in vivo орчинд үр нөлөөг судалдаг. Дараа нь саармагжуулагч эсрэгбиеийн антигентай холбогдсон бүрдлийг судалдаг. Эпитопийг тодорхойлж, иммуногенийг боловсруулсны дараа туршилтын амьтан болон хүн дээр туршиж үнэлнэ.

Дээр дурдсан эсрэгбиеэс гадна scFvs ба Fabs нь COVID-19-ийг эмчлэхэд найдвар төрүүлсээр байгаа бөгөөд SARS-CoV ба MERS-CoV-той тэмцэх үйлд үр дүнтэйгээ хэдий нь үзүүлчихээд байгаа юм. ScFv 80R нь S1 дэд нэгжтэй харилцан in vitro орчинд SARS-CoV-ийг үр дүнтэй

Хүснэгт 2. Эмнэлзүйн 1 болон 2 шатны вакцин хөгжүүлэлтийн байдал

Вакцины төрөл	Вакцин	Хөгжүүлэгч	Эмнэлзүйн шат	Тунгийн тоо	Тунгийн давтамж
Идэвхгүйжүүлсэн вакцин	Идэвхгүйжүүлсэн	Хятадын Анагаах Ухааны Академи, Анагаахын биологийн хүрээлэн	1/2 шат	2	0, 28 дах өдөр
	Идэвхгүйжүүлсэн	Бүгд найрамдах Казахстан улсын Биологийн аюулгүйн асуудлын судалгааны хүрээлэн	1/2 шат	2	0, 21 дэх өдөр
	Бүхэл вирион идэвхгүйжүүлсэн мРНХ	Bharat Biotech	2 шат	2	0, 14 дэх өдөр
		Curevac	2 шат	2	0, 28 дах өдөр
РНХ вакцин	мРНХ	Arcturus/Duke-NUS	1/2 шат	Тодорхой биш	Тодорхой биш
	LNP-nCoVsaRNA	Лондонгийн Эзэн хааны коллеж	1 шат	2	Тодорхой биш
	мРНХ	Ардын чөлөөлөх армийн цэргийн академи /Walvax Biotech	1 шат	2	0, 14 эсвэл 0, 28 дах өдөр
ДНХ вакцин	Нэвчүүлэлттэй ДНХ плазмид вакцин	Inovio Pharmaceuticals/ ОУ-ын вакцины хүрээлэн	1/2 шат	2	0, 28 дах өдөр
	ДНХ плазмид вакцин + Хучлүүр	Осакагийн Их Сургууль/ AnGes/ Takara Bio	1/2 шат	2	0, 14 дэх өдөр
	ДНХ плазмид вакцин	Cadila Healthcare Limited	1/2 шат	3	0, 28, 56 дах өдөр
	ДНХ вакцин (GX-19)	Genexine Consortium	1/2 шат	2	0, 28 дах өдөр
Репликацийн бус вирусийн вектор Репликацитай вирусийн вектор	Репликацигүй S кодлосон Симиан Аденовирус (GRAd)	ReiThera/LEUKOCARE/Univercells	1 шат	1	Тодорхой биш
	Улаан бурханы вектор суурилсан	Пастерийн хүрээлэн/Themis/Питцбургийн их сургууль, CVR/Merck Sharp & Dohme	1 шат	1 эсвэл 2	0, 28 дах өдөр
	Хамрын томуу суурилсан RBD	Бээжингийн Вантай биологийн үйлдвэр /Xiamen University	1 шат	1	Тодорхой биш
Уурлийн дэд нэгж	Матрикс М адъювантай бүтэн урттай рекомбинант SARS-CoV-2 гликопротейн нанопартикл вакцин	Novavax	2 шат	2	0, 21 дэх өдөр
	Хучлүүртэй рекомбинант уураг (РХД-димер)	Anhui Zhifei Longcom Biopharmaceutical/Institute of Microbiology, Хятадын ШУ-ы Академи	2 шат	2 эсвэл 3	0, 28 эсвэл 0, 28, 56 дах өдөр
	RBD-д суурилсан	Kentucky Bioprocessing, Inc	1/2 шат	2	0, 21 дэх өдөр
	S уураг (бакуловирусийн бүтээгдэхүүн)	Sanofi Pasteur/GSK	1/2 шат	2	0, 21 дэх өдөр
	S уурлийн рекомбинант тример агуулсан вакцин	Clover Biopharmaceuticals Inc./GSK/Dynavax	1 шат	2	0, 21 дэх өдөр
	Advax хучлүүртэй рекомбинант S уураг	Vaxine Pty Ltd/Medytox	1 шат	1	Тодорхой биш
	MF59 хучлүүртэй молекул кламптай тогтворжуулсан S уураг	Queensland-ийн их сургууль/CSL/Seqirus	1 шат	2	0, 28 дах өдөр
	S-2P уураг + CpG 1018	Medigen Vaccine Biologics Corporation/NIAID/Dynavax	1 шат	2	0, 28 дах өдөр
	RBD + Хучлүүр	Instituto Finlay de Vacunas, Cuba	1 шат	2	0, 28 дах өдөр
	Пептид	FBRI SRC VB VECTOR, Rospotrebnadzor, Koltsovo	1 шат	2	0, 21 дэх өдөр
	RBD (sf9 эсэд экспрессэгдэгч бакуловирусийн бүтээгдэхүүн)	Сичуан их сургууль, Баруун Хятадын эмнэлэг	1 шат	2	0, 28 дах өдөр
	SARS-CoV-2 HLA-DR пептид	Tuebingen их сургуулийн эмнэлэг	1 шат	1	Тодорхой биш
	GSK эсвэл Dynavax хучлүүртэй ургамлаас гарган авсан VLP	Medicago Inc.	1 шат	2	0, 21 дэх өдөр

саармагжуулдгаа харуулжээ.[85] Эдүгээ RBD-д өвөрмөц хүний-scFv Fc5C2 нь SARS-CoV-2-ийн S уургийг үр дүнтэй саармагжуулж, ACE2 рецепторыг S уурагтай холбогдохыг саатуулдаг болох нь тогтоогдоод байна.[86] MERS-27 ба m336 зэрэг хүний mAbs эсвэл Fabs нь MERS-CoV-ийн дипептид пептидаз 4 (DPP4)-ийг холбогч хэсэгтэй давхцдаг RBD-ний эпитопуудыг таних чадвартай ба, in vitro орчинд зохиомол эсвэл амьд MERS-CoV-ийг саармагжуулж байжээ.[87,88] scFv ба Fabs эсрэгбиеийн хэрчмүүд нь нийлэгжих хугацаа богино, антигенийг өндөр авцаал чанартай холбодог ба тогтвортой бүтэцтэй байдаг.[89] Гэсэн хэдий ч scFv ба Fab нь SARS-CoV-2-ийн эсрэг хэр үр дүнтэй тогтооход нэмэлт судалгаа шаардлагатай байна.



Зураг 4. Саармагжуулагч эсрэгбиеийг гарган авах аргачлал

a Вирусийн халдвар аваад эдгэрсэн хүнээс моноклон эсрэгбиеийг ялган авдаг. Антиген өвөрмөц В эсийг ялган авч, хүнд ба хөнгөн гинжний генийг хослолыг гүнзгийрүүлсэн секвенсийн аргаар тогтооно. Үйл ажиллагааг шинжилж сонгосон генийн хослолыг моноклон эсрэгбие гарган авахад ашиглана. b Хүнийжүүлсэн саармагжуулагч эсрэгбиеийг хулгана гэх мэт дархлаажуулсан трансген амьтны загвараас гарган авдаг. c Нано биеэнцэрийг тэмээг вирусийн уургаар дархлаажуулж, VHH ген агуулсан дараалыг фагаар зөөвөрлөн гарган авна.

SARS-CoV-2 халдвар авсан эмчлүүлэгчдийг эмчлэх үр дүнтэй эмчилгээний арга байхгүй байгаа нь SARS-CoV-2-ийг өвөрмөцөөр онилсон үйлчлэх замаар ACE2-тэй өрсөлдөн холбогдож саармагжуулагч эсрэгбиеийг цаашид хөгжүүлэх, мөн SARS-CoV-2-той солбицон үйлчлэх чадвартай SARS-CoV ба MERS-CoV-ийн эсрэг саармагжуулагч эсрэгбиеийг үргэлжлүүлэн судлах шаардлагатай байгааг харуулж байна. Халдварлах чадвар өндөртэй Spike D614G мутацийг агуулсан SARS-CoV-2 хувилбар нь газарзүйн олон бүс нутагт зонхилох хэлбэр болоод байна.[90] Коронавирусийн хэв шинжүүд мутацид орох өндөр чадвартайн улмаас, саармагжуулагч эсрэгбие нь хэд хэдэн хязгаарлагдмал талтай байгааг анхааруулан тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, өөр өөр эпитопыг таньснаар хүч хавсран саармагжуулах чадвартай эсрэгбиеийг ашиглах чиглэлээр цаашдын судалгааг хийх шаардлагатай байна. RBD-ний давхацдаггүй, хоёр тусдаа эпитоптой холбогддог REGN10987 ба REGN10933 саармагжуулагч эсрэгбиеийн хослол нь зайлсхийдэг мутант үүсгээгүй байна.[91,92] Ван нарын тодорхойлсон 553-13 эсрэгбие нь тэдний олж илрүүлсэн бусад саармагжуулагч эсрэгбиеийн саармагжуулах чадавхийг эрс нэмэгдүүлж байсан байна.[93] Гэвч эсрэгбиеийн холимгоор эмчлэх нь өндөр өртөгтэй, урт хугацааны дархлааны урвалыг өдөөдөггүй байж болох юм. Тиймээс эсрэгбиеийн холимгоор эмчлэх аргын үр дүнг сайжруулах, эмнэлзүйд хэрэглэхэд боломжтой бөгөөд аюулгүй эсэхийг үнэлэхийн тулд үргэлжлүүлэн чармайх шаардлагатай байна.

Вакцин бүтээхтэй холбоотой аюулгүй байдлын асуудал

Вакцины хамгийн чухал шалгуур бол аюулгүй байдал байдаг. SARS-CoV ба MERS-CoV-ийн вакцин бүтээсэн өмнөх туршлага нь вакцины дараах Th2 эсийн хариу урвалаас хамааралтай уушгины дархлааны эмгэгийн асуудалд илүүтэй анхаарахыг сануулж байгаа юм (Зураг 5b).[67] Th2 нь интерлейкин (IL) 4, IL-5, IL-10, IL-13 зэрэг Th2-ийн цитокин ялгаруулдаг Т эсийн дэд бүлэг бөгөөд эдгээр цитокины гаж ялгарал нь эозинофилийн нэвчдэс үүсгэдэг дархлааны урвалыг нөхцөлдүүлдэг. Хулганы загварт дөрвөн өөр төрлийн SARS-CoV вакциныг тарьсаны дараа Th2 хэвшинжийн хэт мэдрэгшлийн маркер гэж үздэг эозинофил эсийн уушгины нэвчдэс бүхий Th2 хэвшинжийн дархлааны эмгэг үүсч байжээ.[94] Энэ урвал нь идэвхигүйжүүлсэн MERS-CoV-ийн вакцинаар дархлаажуулсан хулганад мөн илэрч байсан бөгөөд эозинофилийн нэвчдэс үүсч, IL-5 ба IL-13-ийн хэмжээ вакцин хийхээс өмнөх үеийнхээс ихэссэн байжээ.[95] Түүнээс гадна вакцины дараах дархлааны эмгэг урвал нь вакцинд N уураг байгаатай холбоотой гэсэн таамаглал байдаг ч үүнийг нотлох нэмэлт судалгаа шаардлагатай байгаа юм.[96,97] SARS-CoV-2 халдвар авсан өвчтнүүдэд илрэх цитокины өөрчлөлтийн талаарх сүүлийн үеийн судалгаа нь Th2 эсийн цитокины ялгарал нэмэгдэж, энэ

Хүснэгт 3. SARS-CoV-2 руу чиглэсэн үр дүнтэй саармагжуулагч эсрэгбие

Эсрэгбиеийн төрөл	Эсрэгбиеийн нэр	Эсрэгбиеийн үүсэл	Саармагжуулах механизм	Эх сурвалж
Моноклон эсрэгбие	CC12.1	Хүн	RBD-А эпитопийг чиглэнэ	67
	BD-368-2	Хүн	ACE2 холбогдох хэсэгтэй холбогдоно	68
	B38, H4	Хүн	RBD-тэй холбогддог ACE2-той бүрэн өрсөж холбогдоно	69
	B5	Хүн	РХД-тэй холбогдоно, ACE2-той хэсэгчлэн өрсөж холбогдоно	69
	H2	Хүн	RBD-тэй холбогдоно, ACE2-той өрсөлдөхгүй	69
	CB6	Хүн	ACE2-ийн эпитоптой холбогдоно	71
	P2B-2F6	Хүн	ACE2-тэй өрсөж холбогдоно	71
	31B5	Хүн	ACE2-RBD харилцан үйлчлэлийг саатуулна	72
	32D4	Хүн	ACE2-RBD харилцан үйлчлэлийг саатуулна	72
	COVA1-18	Хүн	ACE2-RBD харилцан үйлчлэлийг саатуулна	73
	COVA2-15	Хүн	ACE2-RBD харилцан үйлчлэлийг саатуулна	73
	CV30	Хүн	S-ACE2 харилцан үйлчлэлийг дарангуйлна	74
	CV1/CV35	Хүн	RBD-ээс бусад эпитоптой холбогдоно	74
	ADI-55689	Хүн	ACE2 холбох бүсийн захын хэсэгт холбогдоно	76
	ADI-56046	Хүн	hACE2 ба CR3022-тай өрсөж холбогдоно	76
	S309	Хүн	S уургийн доторх гликан агуулсан эпитопийг чиглэх ба Fc хамааралт эффектор механизмыг нөхцөлдүүлнэ	66
	47D11	Трансген H2L2 хулгана	Spike-рецепторын харилцан үйлчлэлийг саатуулахгүйгээр RBD-ийн эпитоптой холбогдоно	75
	REGN10987 болон REGN10933	Хулгана, Хүн	RBD-ийн 2 тусдаа эпитоптой холбогдоно	89, 90
Fc-холбосон	VHH-72-Fc	Тэмээ	RBD-ийн динамик ба рецептор холболтыг саатуулна	81
Нано биенцэр	n3088, n3130	Хүн	RBD-д байрлах далд эпитопийг чиглэнэ	82
scFv-Fc	5C2	Хүн	ACE2-ийг S уургатай холбогдохыг дарангуйлна	84


нь уушгины дархлааны эмгэгийг нөхцөлдүүлэх боломжтойг харуулсан байна.[98–100] Тиймээс SARS-CoV-2-ийн эсрэг вакцин бүтээхдээ Т эсийн хариу урвалыг хяналтыг шийдэхэд анхаарах шаардлагатай байна. Вакцинаар өдөөгдсөн шингэний дархлааны хариу урвал нь коронавирусийн халдвараас хамгаалах үр дүнтэй арга байж болох боловч эсрэгбиеийн эмгэг хариу урвал нь өвчтнүүдийн биеийн байдал хүндрэхэд хүргэдэг байж болзошгүй юм (Зураг 5b). SARS-CoV халдварлуулсан макака бичний загварт вакцинаар өдөөгдсөн S-өвөрмөц IgG нь макрофаг эсийн үрэвслийн шийдлийн урвалыг өдөөн хүнд хэлбэрийн цочмог уушгины гэмтэл (ALI) үүсгэж байсан ба Fc гамма рецептор (FcγR)-ыг хориглоход энэ нөлөө нь буурч байжээ.[101] Түүгээр ч зогсохгүй нас барсан эмчлүүлэгчдэд цочмог халдварын үед саармагжуулагч эсрэгбиеийн титр эдгэрсэн хүмүүсийнхтэй харьцуулахад богино (эрт) хугацаанд хэт ихсээд дараа нь илүү хурдан буурч, үүгээрээ дархлаа тогтолцооны үйлийг бүхэлд нь доголдуулж, уушги ба дэлүүнд дархлааны эмгэг нөлөө үзүүлж байсан байна.[101,102] Эндээс хүнд хэлбэрийн SARS-CoV-2-ийн халдвартай хүмүүст хүчтэй IgG-гийн урвал өдөөгдөж эсрэгбиеийн титр их байх ба энэ нь эмнэлзүйн явц хүндрэхтэй ба SARS-CoV-2-ийн халдварын эсрэгбие-хамааралт хүчжүүлэлт (ADE) гэж нэрлээд байгаа гаж үзэгдэл үүсэхтэй холбоотой гэж үзэхээр байна.[103,104] SARS-CoV-2-ийн вакцин нь эсрэгбиеийн эмгэг урвал үүсгэх эсэх нь одоогоор тодорхойгүй байгаа бөгөөд SARS-CoV-2-ийн вакцины нөлөөгөөр уушги гэмтэх магадлалыг нэмж судлах шаардлагатай байна. Вакцинаар дархлаа тогтоход нас нөлөөлдөг. Туршилтаар хөгширсөн амьтдыг дархлаажуулах оролдлого хийх үед уушгинд эозинофил эст дархлааны эмгэг урвал үүсч байжээ. Хамгийн хүндрэлтэй нь, вакцинжуулсан хөгшин амьтадын бүлгийг залуу амьтадын бүлэгтэй харьцуулахад саармагжуулах эсрэгбиеийн титр илт бага байсан байна.[97,105] Үндсэндээ чихрийн шижин, даралт ихсэх ба зүрх судасны өвчин зэрэг суурь өвчтэй өндөр настай хүн амын хэсэг нь SARS-CoV-2-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй байдаг байна.[54,106] Ахмад настанд өвчний явц хүнд байдгийг тооцон үзвэл вакцины эмнэлзүйн өмнөх баталгаажуулалтын судалгаанд хөгширсөн амьтны загварт туршилт хийх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Вакциныг боловсронгуй болгох боломжит аргууд

Антигений загвар

Эзэн биед хамгаалах дархлааны урвал өдөөдөг Т, В эсийн дархан давамгай эпитопийг тодорхойлох нь үр дүнтэй вакцин үйлдвэрлэхэд чухал үүрэгтэй. SARS-CoV-2-ийн омгууд нь бүх геномынхоо түвшинд SARS-CoV-тай ойролцоогоор 79%-ийн ижилдүү чанартай гэж үзээд SARS-CoV эпитопуудтай ижилсүүлэн, SARS-CoV-2-ийн геномын дараалын мэдээлэлд суурилсан хайлтын арга ашиглан (epitope prediction tool) В эс ба ба Т эсийн багц эпитопууд

байгааг урьдчилан тогтоож (epitope prediction) олохыг сүүлийн судалгаануудын үр дүн харуулаад байна.[107]



Зураг 5. Вакцинаар өдөөгдсөн дархлааны хариу урвал

Антиген илчлэгч эсүүд (APCs) нь вакцины антигенийг боловсруулж $CD8^+$ Т эс болон $CD4^+$ Т эсэд илчилдэг. Th1 эсээс ялгарах цитокиноор $CD8^+$ Т эсүүд идэвхижиж, халдварласан эсийг устгадаг. Th2 эсийн цитокин нь В эсийг ялгаран хөгжихөд тусалдаг. Идэвхижсэн В эсүүдээс саармагжуулагч эсрэгбие үүсдэг. Гэвч эмгэг дархлааны хариу урвал болох хэт идэвхижсэн Th2 эсийн урвал, эсрэгбие хамааралт урвалын нөлөөгөөр уушги гэмтдэг.


